



**ХЭНТИЙ АЙМАГ  
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 25

Бор-Өндөр

**ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ  
ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоол, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, салбар зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бор-Өндөр суманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад, суманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж, үр дүнтэй ажиллахыг ГХУСАЗСЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ